



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 07 өдөр

Дугаар А/434

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.4 дэ заалт, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 474 дүгээр тогтоолын 2 дугаар заалт, Засгийн газрын 2021 оны 161 дүгээр тогтоолын 3 дугаар заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Зөөлөн тэмүүлэл констракшн” ХХК-ний хийж гүйцэтгэсэн Биеийн тамир, спортын ордны барилгын их засвар (Жаргалант сум)-ын ажлыг хүлээж авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Түмэндэмбэрэл (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүд: Д.Эрдэнэбат (Аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Ц.Даваасамбуу (Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)

У.Болдбаяр (“Зөөлөн тэмүүлэл констракшн” ХХК-ний захирал)

О.Тунгалаг (Жаргалант сумын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн)


Ч.Түмэндэмбэрэл (Биеийн тамир, спортын газрын дарга)

Нарийн бичгийн дарга: С.Өнөржаргал (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. “Зөөлөн тэмүүлэл констракшн” ХХК-ний хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Түмэндэмбэрэл)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ

Т.ДЭЛГЭРСАЙХАН



8400001 1045
Zah A/434 Ba